



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 04 сарын 04 өдөр

Дугаар 01/196

Арвайхээр

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн 03/03 дугаар тогтоолоор батлагдсан “Өвөрхангай аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 3.4.1.3, 3.4.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Өвөрхангай аймаг Франц улсын Аллиер муж хоорондын хамтын ажиллагааны хүрээнд тус улсын “АПАУ” нийгэмлэгийн төлөөлөгчид Хархорин, Бат-Өлзий, Баян-Өндөр, Сант, Арвайхээр сумдад эрүүл мэнд, боловсрол, хөдөө аж ахуйн салбарын үйл ажиллагаатай танилцах, хамтран ажиллах боломжийг судлах арга хэмжээний зардлыг хавсралтаар баталсугай.

2.Хавсралтад тусгагдсан 5,978,025 (таван сая есөн зуун далан найман мянга хорин тав) төгрөгийг аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс (Ц.Идэрсайхан)-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



А.ИШДОРЖ

6223 11 0366

D:My Doc. Zahiramj. Zasag darga

Аймгийн Засаг даргын 2023 оны 04 дүгээр
сарын 04-ны өдрийн 1116 дугаар
захирамжийн хавсралт

ФРАНЦ УЛСЫН АЛЛИЕР МУЖИЙН "АПАУ" НИЙГЭМЛЭГИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ӨВӨРХАНГАЙ АЙМАГТ АЖИЛЛАХ ЗАРДЛЫН ТООЦОО

№	Зардлын төрөл	Нэг бүрийн үнэ	Нийт
1	Хархорин, Бат-Өлзий, Баян-Өндөр, Сант, Арвайхээр сумдад ажиллах шатахуун (АИ92)	357.5 /л/х 2470 төгрөг	883,025
2	Хархорин, Арвайхээр сумдад байрлах зочид буудлын зардал (13 өдөр)	9хүн х35000	4,095,000
3	Хоол (10 өдөр)	10 хүн х 10.000	1,000,000
Нийт			5,978,025

-oOo-